



ХӨСҮТ-ИЙН ЗАХИРГАА

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН

ХОРОО

ХАМТЫН ГЭРЭЭ

ГЭРЭЭ БАТЛАГДСАН: 2023.05.24

ГЭРЭЭ ДУУСАХ: 2026.05.24

2023 ОН

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООТОЙ БАЙГУУЛСАН 2023 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

2023 оны 05 дугаар сарын 23 өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээг Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенци, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг тус тус үндэслэн нэг талаас Халдварт өвчин судлалын үндэсний төв /цаашид ажил олгогч гэх/, нөгөө талаас нийт ажилчдыг төлөөлж Үйлдвэрчний эвлэлийн хороо /цаашид ажилтны төлөөлөгч гэх/, хамтад нь /талууд гэх/ харилцан тохиролцож байгуулав.

1.2 Тус гэрээгээр нийт Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, ажилтнуудын хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу хөдөлмөрийн хуулиар тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй бусад нийгэм болон эдийн засгийн харилцааг зохицуулна.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1 Хамтын гэрээ нь гурван жилийн хугацаанд үйлчилнэ. Гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд харилцан тохиролцож, анх байгуулсан хугацаанаас илүүгүй хугацаагаар сунгаж болно.

2.2 Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

2.3 Байгууллагын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нөхцөлд хамтын гэрээ мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.4 Хамтын гэрээнд үндсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговор, нөхөн төлбөрийн хэмжээ, тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ, түүний зардал, Ажилтны төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, бололцоог хангах арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас эрүүл мэнд нь хохирсон ажилтныг дэмжих арга хэмжээ зэргийг тусгана.

2.5 Хамтын гэрээний заалтуудаас илүү нөхцөлөөр байгуулагдсан хууль, хөдөлмөрийн гэрээний заалтууд, цалин хөлс, амралт, ажил эрхлэлттэй холбоотой тогтоол шийдвэрүүд хэвээр мөрдөгдөнө.

2.6 Энэхүү гэрээ нь тус төвийн нийт ажилтнуудыг бүрэн хамарч үйлчилнэ.

- 2.7 Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд бичгээр гаргаж, тухайн үед хэлэлцэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 2.8 Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцоно.

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР

- 3.1 Ажил олгогч нь ажилтнуудын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, унаа, хоолны зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүтэн олгож, өмнөх хүрсэн түвшингээс бууруулахгүй, аль болох нэмэгдүүлж ажиллана.
- 3.2 Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, инфляцын түвшин, гүйцэтгэлийн санхүүжилт, ажлын ачаалалтай уялдуулан, Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх тохиолдол тус бүрд тухайн нэмэгдүүлсэн хувиар нэмэгдүүлнэ.
- 3.3 Гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ түншлэлийн зарчмыг баримтлан тооцоолол, судалгаа, бодит нөхцөл байдлыг үнэлэн хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.4 Цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байна.
- 3.5 Ажилтан гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авна.
- 3.6 Ажил олгогч нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллыг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүтэн олгоно.
- 3.7 Цалинг сард 2 удаа олгох бөгөөд сарын 15, 30-ны өдөр олгоно. Үндсэн цалин хөлсийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй бол хэтрүүлсэн хоног тутамд 0.5 хувийн алданги тооцож ажилтанд нөхөн олгоно.
- 3.8 Ажил олгогч ажилтанд цалин хөлс олгох бүрд тухайн хугацаанд олговол зохих цалин хөлсний бүрэлдэхүүн, суутгалын хэмжээ, түүний үндэслэл, олгосон цалин хөлсний хэмжээг цахим хэлбэрээр мэдэгдэнэ.
- 3.9 Ажлын цагийг богиносгосон ажилтны цалин хөлсийг цагаар, эсхүл хийснээр тооцож олгох бөгөөд богиносгосон цагт ногдох цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч нэмж олгоно.
- 3.10 Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд байнгын тогтмол нэмэгдэл хөлсийг /хөдөлмөрийн нөхцөлийн, ажилласан хугацааны, боловсролын болон мэргэшлийн зэргийн, хавсран ажилласны, хариуцлагын гэх мэт/ оруулж тооцно
- 3.11 байнгын тогтмол нэмэгдэл хөлсийг /хөдөлмөрийн нөхцөлийн, ажилласан хугацааны, боловсролын болон мэргэшлийн зэргийн, хавсран ажилласны, хариуцлагын гэх мэт/ оруулж тооцно
- 3.12 Шөнийн цагаар ажилласан ажилтны шөнийн 8 цагийн нэмэгдлийг төсөвт тусгаж батлуулах хүртэл цагийн 1000 төгрөгөөр тооцож, төсөв батлагдсанаас хойш дундаж цалин хөлснөөс 1.2 дахин нэмэгдүүлж олгоно.
- 3.13 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд үндсэн цалингийн 10 хувиар бодож нэмэгдэл олгоно.
- 3.14 Ажил олгогч нь ажилтны унаа, хоолны зардлыг ажлын өдрийн 5000 төгрөгөөр тооцон ажилчдад сар бүр олгоно.
- 3.15 Ажил олгогч нь ажилтанд Эрүүл мэндийн салбарын 2017-2018 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 3 дугаар бүлгийн 3.1 дэх заалтыг үндэслэн ажилтанд ажиллаж байх хугацаанд нь зөрүү цалинг нэмэгдлээр сар бүр тогтмол олгоно. Жич: Зөрүү цалинг тус

төвийн Ерөнхий захирлын 2019 оны А/39 дүгээр тушаалын хавсралтын дагуу тогтмол олгоно.

3.16 Ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор ажилласан жилийн нэмэгдлийг зохих журмын дагуу ажилтны сарын үндсэн цалингаас бодож олгоно.

3.17 Ажилтанд мэргэшлийн болон боловсролын зэргийн нэмэгдлийг зохих журмын дагуу ажилтны үндсэн цалингаас бодож олгоно.

3.18 Ажил олгогч улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажилтны ажлын үр дүн, бодит ажилласан хугацаа, гүйцэтгэлийг харгалзан сар бүр үндсэн цалингийн 20 хүртэл хувиар тооцож, улиралд 60 хүртэл хувиар хөдөлмөр оролцооны коэффициент тооцож олгоно.

3.19 Ажилтны ажил гүйцэтгэх үр чадвар, ажлын арга барил, идэвх санаачлагыг дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор нийт ажилчдад үр чадварын нэмэгдэл олгоно.

3.20 Ажил олгогч нь Сүрьеэгийн эмнэлэг, тасаг, тандалт судалгааны нэгжид ажиллаж байгаа хүний их эмч, дүрс оношилогооны эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, сувилагч, лабораторийн болон рентген туяаны техникч, асрагч/үйлчлэгчид албан тушаалын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг тухайн албан тушаалыг эрхлэх хугацаанд сар бүр олгоно.

3.21 Ажилтан хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрсөн тохиолдолд ажил олгогч гүйцэтгэх ажил үүрэг, түүнд олгох цалин хөлсийг ажилтантай урьдчилан тохиролцоно.

3.22 Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил хослон гүйцэтгүүлэх эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүргийг гүйцэтгэсний болон нэмэгдэл хөлсний хэмжээг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

3.23 Ажилтантай тохиролцсоноор адил чанарын өөр ажилд түр шилжүүлэн ажиллуулсан тохиолдолд шилжүүлсэн хугацаанд цалин хөлс нь буурсан бол цалин хөлснийх нь зөрүүтэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч олгоно.

3.24 Ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журмын дагуу удирдах, албан тушаал эрхэлж байх хугацаанд нь албан тушаалаас шалтгаалж хариуцлагын нэмэгдэл 10-25 хувийг үндсэн цалингаас тооцож олгоно.

3.25 Ажил олгогч нь арга зүйч сувилагч, тасгийн няравтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулж сар бүр үндсэн цалингийн 10 хувиас доошгүй хэмжээний нэмэгдэл хөлс олгоно.

3.26 Ажил олгогч нь асрагч үйлчлэгч нарт бохирын нэмэгдэл үндсэн цалингийн 5 хувийг сар бүр олгоно.

3.27 Ажил олгогч нь ажилтны ээлжийн амралтын цалинг тухайн жилийн ажлын дундаж цалин хөлснөөс тооцож олгоно. Амралтын мөнгийг хугацаанд нь өгөөгүй тохиолдолд хоног тутамд 0.5 хувийн алданги тооцож ажилтанд олгоно.

3.28 Ажилтны ажилласан илүү цагийн хөлс олгох нэг цагийн дундаж цалин хөлсийг тооцохдоо ажилтны нэг өдөрт ногдох цалинг ажлын 7 цагт хуваан тооцно.

3.29 Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.

3.30 Ажил олгогч нь ээлжийн хуваарийн дагуу жижүүрт хоносон эмч нарыг нөхөн амруулаагүй бол ажилласан илүү цагийг Баасан, Бямба гаригт бүтнээр нь олгоно.

3.31 Ажил олгогч нь илүү цагаар ажилласан, шөнийн цагаар ажилласан, долоо

хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг биеэр амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

3.32 Ажил олгогч нь ажилтныг ээлжийн хуваарийн дагуу болон илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг зохих журмын 2.0 дахин нэмж олгоно.

3.33 Ажил олгогч дуудлагаар ажиллуулах өдөр, цагийг ажилтанд 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.

3.34 Ажилтантай байршил, хугацааг тохиролцож, ажлын цагаас бусад цагт дуудаж ажиллуулахад бэлэн байхаар хүлээлгэсэн бол хүлээлгэсэн хугацааг ажилласан цагт тооцох, дуудлагаар ирж ажиллаж буй ажилтны дуудлагын цагийг нэмэгдэл хөлс олгох журмаар бодож олгоно.

3.35 Алсын дуудлаганд өвчтөн тээвэрлэж буй болон албан томилолтоор ажил гүйцэтгэж буй ажилтны илүү цагийн хөлс, томилолтыг холбогдох журмын дагуу олгоно.

3.36 Ажил олгогч нь ажлын бус цагийн нэмэлт тусламж, үйлчилгээг гэрээ байгуулсны үндсэн дээр үзүүлсэн тохиолдолд орлогын 40-өөс доошгүй хувийг уг ажилтанд олгоно.

3.37 Ажил олгогч нь байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ажилдаа ирж чадаагүй ажилтанд үндсэн цалингийн 60 хувиас доошгүй хэмжээний олговор олгоно.

3.38 Ажил олгогч нь гамшиг, саатлын хор уршгийг арилгахад биеэр оролцсон ажилтанд үндсэн цалингаас доошгүй хэмжээний нөхөн олговор олгоно.

3.39 Хуульд заасны дагуу ажилтны цалин хөлснөөс суутгал хийх тохиолдолд ажилтанд урьдчилан мэдэгдэж, журмын дагуу суутгал хийнэ.

ДӨРӨВ. АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГИЙН ТАЛААР

4.1 Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийг өдөрт 8 цагаар тооцож, 8:30-16:30 хүртэл үргэлжлэх буюу 7 хоногт 40 цаг, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийг өдөрт 7 цагаар тооцож, 8:30-15:30 цаг хүртэл үргэлжлэх ба 7 хоногт 35 цаг, рентген, шүд, физик эмчилгээ, дүрс оношилгоо, лаборатори, эмгэг судлаач эмч, ажилтны ажиллах цагийг өдөрт 6 цагаар тооцож 8:30-14:30 цаг хүртэл үргэлжлэх ба 7 хоногт 30 цаг ажиллах бөгөөд энэ заалт жинхэнэ үйл ажиллагааны үед хамаарна.

4.2 Амрах, хооллох, завсарлага эхлэх, дуусах хугацааг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

4.3 Ажил үүргийн онцлогоос шалтгаалан хооллох завсарлага авах боломжгүй ажилтныг ажлын байранд нь хооллох бололцоогоор хангах бөгөөд уг хугацааг ажилласан цагт тооцно.

4.4 Ажилтныг хуулиар тогтоосон ажлын цагийн дээд хязгаараас хэтрүүлэн ажиллуулахгүй байх бөгөөд ингэж ажиллахыг шаардсан үед ажилтан ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

4.5 Ажлын хэт ачаалал, уртасгасан цагаар ажиллах, ажлаас халшрах хамшинж үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ээлжийн хуваарьт ажилтанд ээлтэй зохицуулалт хийнэ.

4.6 Ажил олгогч ээлжийн ажлын цаг, хуваарийг ээлжийн ажил эхлэхээс 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.

4.7 Ажилтныг хоёр ээлжинд дараалуулан ажиллуулахыг хориглоно.

4.8 Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба

түүнээс дээш байна.

4.9 Шөнийн цагаар ажилласан ажилтныг дараагийн ажлын өдөр нь шөнө ажилласан цагаас багагүй хугацаагаар нөхөн амраана.

4.10 Шөнийн ээлжнээс буусан ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол үргэлжлүүлэн хурал, зөвлөгөөн, сургалт зэрэг үйл ажиллагаанд хамрагдахыг шаардахгүй.

4.11 Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх (эцэг)-ийг, 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн ээлж, илүү цагаар, нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглоно.

4.12 Хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан 6 сар хүртэлх насны хүүхэдтэй буюу 1 хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд 2 цагийн, 6 сараас 1 хүртэлх насны, эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд 1 цагийн завсарлага нэмж олгоно. Ажилтны хүсэлтээр хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажлын цагийн богиносгосон хэлбэрт шилжүүлж, ажилласан цагт тооцон, олговор олгоно.

4.13 Ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш зургаан сар ажилласан бол ээлжийн амралт авах эрх үүсэх бөгөөд ажилтанд ээлжийн амралтыг нь жил бүр олгож, тухайн жилд нь биеэр эдлүүлэх ба захиргааны шийдвэрээр ажиллуулсан бол нөхөн амраана.

4.14 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын үндсэн хугацаан дээр хуулиар заасан нэмэгдэл амралтыг олгоно.

4.15 Ажилтан зохих журмын дагуу хувийн чөлөө авах эрхтэй бөгөөд хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

ТАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

5.1 Ажил олгогч Ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжинд нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

5.2 Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулан байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулна.

5.3 Хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг, байршил, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цаг, цалин хөлс олгох журам болон бусад нөхцөлийг тусгах ба хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэж талууд гарын үсэн зурах бөгөөд гэрээний нэг хувийг ажилтанд өгнө.

5.4 Талууд тохиролцож хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж болно.

5.5 Ажил олгогч ажилтныг ажилд авахдаа тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангах эсэхийг нь шалгах зорилгоор туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээний хугацаа гурван сараас илүүгүй байх бөгөөд харилцан тохиролцсоноор нэг удаа гурван сараас илүүгүй хугацаагаар сунгаж болно.

5.6 Хөдөлмөрийн гэрээнд заасан ажил мэргэжлийн дагуу ажиллах бололцоо олгож, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана.

5.7 Ажилтны ажлын байрны тодорхойлолтыг тусгай загварын дагуу ажилтантай

тохирсоны үндсэн дээр батална.

5.8 Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

5.9 Ажилтан зөвшөөрөөгүй тохиолдолд хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг ажилтанаас шаардаж болохгүй. Ажилтан хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрсөн тохиолдолд ажил үүрэг, түүнд олгох цалин хөлсийг ажилтантай урьдчилан тохиролцоно.

5.10 Тодорхой шалтгааны улмаас ажлын байрыг олноор цөөрүүлэх, орон тоо, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ ажил олгогч нь Ажилтны төлөөлөгчид 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангаж ажиллана.

5.11 Ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 3 жил хүртэл хугацаа дутуу байгаа, эрх толгойлсон бөгөөд насанд хүрээгүй 2-оос дээш хүүхэдтэй ажилтнуудыг цомхотголд хамруулахгүй бөгөөд тухайн ажлын байр цомхотголд орвол цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл бууруулахгүй өөр ажлаар хангана.

5.12 Төвийн эмч, ажилтнуудыг аливаа халдлага, дайралт, гүтгэлэг зэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн орчныг бий болгож, үйлчлүүлэгчийн хариуцлагын тогтолцоог сайжруулна.

5.13 Төвийн эмч, ажилтнуудын цалин хөлс, нийгмийн хамгаалал, ажлын байрны дарамт хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг асуудлыг сайжруулах талаар Ажилтны төлөөлөгчтэй хамтран бодитой ажил зохион байгуулна.

5.14 Ажилтнуудад ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт үзүүлсэн нь хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдвал тухайн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт үзүүлсэн ажилтанд хуулиар болон дотоод журмын дагуу арга хэмжээ авна.

5.15 Төвийн эмч, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг баримталж удирдлагын хувийн үзэл, бодол, улс төр, намын үзэл бодлоор ажлаас чөлөөлөхгүй, ажлын байрны дарамт үзүүлэхгүй байна.

5.16 Төвийн эмч, ажилтнуудыг хариуцлагын болон эрүүл мэнд, амь насны даатгал (Эрсдэлийн даатгал)-д хамруулах асуудлаар Ажилтны төлөөлөгчтэй хамтран эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хамтран ажиллана.

5.17 Ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрүүл мэндийн ажилтанд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтанд тусгагдсан мөнгөн тэтгэмжийг авах эрх үүсээгүй 5 жилээс 24 жил 11 сарын хооронд ажилласан тохиолдолд 3-аас доошгүй сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжийг олгоно.

5.18 Ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсаны улмаас хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол 1 сарын дундаж хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно.

5.19 Халдварт өвчний дэгдэлтийн үед тэтгэвэрт гарсан эмнэлгийн ажилчдыг өөрийн хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ажиллах бөгөөд шаардлагатай тасаг нэгжид хуваариалан ажиллуулна.

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

6.1 Үйлдвэрлэлийн ослыг тогтоох орон тооны бус байнгын комиссыг хуулийн дагуу байгуулж, ажиллуулна.

6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн дагуу ажил олгогч нь ажил үйлчилгээний зардлын 0.5%-аас доошгүй хэмжээний хөрөнгийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

6.3 Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг жилд хоёроос доошгүй удаа нийт ажилтныг хамруулж зохион байгуулна.

6.4 Ажил олгогч нь хүнд хортой нөхцөлд ажилладаг ажилтны жагсаалт гарган, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000/06/19-ний өдрийн 171 дүгээр тушаалын дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүнийг өдөр бүр ажлын байранд нь олгоно.

6.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу ажил олгогч нь ажлын шаардлагаар эрүүл мэндийн хугацаат үзлэгт оруулах ажилтнуудын жагсаалтыг батлан эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулж зардлыг хариуцна.

6.6 Талууд хамтран ажилчдад зориулсан чийрэгжүүлэх кабинет, амрах өрөө зэргийг тогтмол ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

6.7 Ажлын бус цагаар яаралтай дуудагдан ажиллах ажилтныг байгууллагын автомашинаар авч, хүргэж өгнө.

6.8 Ажил олгогч нь ажилтны хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон иж бүрэн, чанартай хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангана.

ДОЛОО. ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖИЙН ТАЛААР

7.1 Талууд нь ажилчдын нийгмийн асуудалд хамтран ажиллана.

7.2 Ажил олгогч нийт ажилчдад хамтран хөнгөлөлттэй үнээр чанар, илчлэг сонголт сайтай хоолоор үйлчлэх арга хэмжээ авч ажиллана.

7.3 Ажил олгогч нь ээлжийн ажилчдад ээлжинд нь 1 удаа, улиран ажилласан тохиолдолд өглөөний хоолоор үнэ төлбөргүй хангана.

7.4 Шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан Эцэгт ажлын 10 өдрийн цалинтай чөлөөг ажил олгогч олгоно.

7.5 Ажил олгогч нь байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ажилдаа ирж чадаагүй ажилтанд үндсэн цалингийн 60 хувиас доошгүй хэмжээний олговор олгоно.

7.6 Ажил олгогч ажилтнуудад дараах тохиолдолд буцалтгүй тусламж олгоно.

7.6.1 Ажилтан нас барсан тохиолдолд ар гэрийнхэнд нь 2 сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгоно.

7.6.2 Ажилтан ажлаа хийж байх үедээ осолд орж хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон тохиолдолд 1 сарын цалинтай тэнцэх буцалтгүй тусламж олгоно.

7.6.3 Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөж нас барсан тохиолдолд амь насны даатгалд хамрагдсаныг үл харгалзан ажилтны ар гэрт холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн олговор олгоно.

7.6.4 Ажилтан хүнд өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 3 сараас дээш хугацаагаар алдаж, тахир дутуу болсон тохиолдолд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг нэг удаа үзүүлнэ.

7.6.5 Ажилтан асрамжинд байгаа гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхдүүд)-ээ хүнд өвчтэй үед нь сахисан тохиолдолд эмчийн магадалгааг үндэслэн ажлын 10 хүртэл хоногийн цалинтай чөлөөг нэг удаа олгож болно.

- 7.6.6 Ажил олгогч нь олон нийтийн байгууллага, нийгэмлэгийн чиглэлээр ажилчдын цалингаас суутгал хийх тохиолдолд ажилчдын санал авна.
- 7.6.7 Ажил олгогч ахмадын өдрөөр нийт ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.
- 7.6.8 Ажил олгогч нь Олон улс, хот, салбарын чанартай биеийн тамир, урлаг уран сайхны тэмцээн уралдаанд амжилт гаргасан ажилтныг үндсэн цалингийн 50 хүртэл хувиар шагнаж урамшуулж болно.
- 7.6.9 Ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Сургалт, хөгжлийн хөтөлбөр"-ийн дагуу гадаад болон дотоодын сургалтад хамруулах, их дээд сургуулийн мэргэшүүлэх сургалтад суралцах эрх авсан ажилтантай гэрээ байгуулж, шаардлагатай тохиолдолд цалинтай чөлөө олгоно.
- 7.6.10 Байгууллагадаа өөрийн идэвхи санаачлагаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалт хийсэн, шинэ техник технологи, инноваци нэвтрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэнд бодит үр ашгийг харгалзан нийт дунгийн 10 хүртэл хувиар урамшуулал олгоно.
- 7.6.11 Байгууллагын шилдэг алба, тасаг нэгж, эмч, ажилтнуудыг жил бүр шалгаруулж мөнгөн урамшуулал олгоно.
- 7.6.12 Эрүүл мэндийн яам, МЭМАҮЭХолбоотой хамтран зохион байгуулдаг "Алтан чагнуур" "Эрдэнийн чагнуур" шагналаар шагнагдсан эмч, сувилагчийг 1 сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулна.
- 7.6.13 Ажилтан хүнд өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 3 сараас дээш хугацаагаар алдаж, тахир дутуу болсон тохиолдолд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажил олгогч нэг удаа үзүүлнэ.
- 7.6.14 Ажил олгогчоос ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, ажилтны тоог цөөрүүлсэн, ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн болон эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон, өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажилласан жилээр тооцон хуулийн дагуу тэтгэмж олгоно.
- 7.6.15 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан эсхүл нас барсан ажилтан, түүний гэр бүлд хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж олгоно.

НАЙМ. МЭДЛЭГ, МЭРГЭШИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- 8.1 Шаардлагатай, хэрэгцээтэй нарийн мэргэжлийн судалгааг гарган, мэргэшүүлэх сургалтанд хамруулна.
- 8.2 Эмч, ажилтнуудыг үндсэн ажлаасаа 3 хүртэлх сарын хугацаатай чөлөөлөгдөн байгууллагын захиалга (шийдвэр)-аар суралцах хугацаанд үндсэн цалингийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.
- 8.3 Эмч, ажилтнууд байгууллагын бодлого, захиалгаар суралцвал сургалтын төлбөрийг ажил олгогч бүрэн хариуцна.
- 8.4 Эмч, ажилтнууд хувиараа суралцах болсон тохиолдолд ажилтны хүсэлтийг харгалзан шаардлагатай үед хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай болон цалингүй чөлөө олгож, ажлын цагийн зохицуулалтыг хийнэ.

8.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлээрээ эрдмийн зэрэг цолны жинхэнэ хамгаалалтад орох үед 7 хоногийн цалинтай чөлөө, мэргэшлийн (ахлах, тэргүүлэх болон зөвлөх) зэргийн шалгалтад орох үед 5 хоногийн цалинтай чөлөө олгоно.

8.6 Талууд хамтран ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд гарсан шалтгааныг судалж багасгах талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

ЕС. ҮЭ-ИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТУХАЙ

9.1 Ажилтны төлөөлөгчийн дарга төвийн удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр орно.

9.2 Ажил олгогч үйлдвэрчний эвлэлийн хорооны саналыг харгалзан хууль тогтоомжинд нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

9.3 Ажилтан нь ажил олгогч, албан тушаалтнаас зөвшөөрөл авахгүйгээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлж, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.

9.4 Ажилтны эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

9.5 Ажилтны төлөөлөгч нь ажилчдын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахдаа гагцхүү хуульд захирагдана.

9.6 Ажил олгогч Ажилтны төлөөлөгчийг үйл ажиллагаагаа явуулахад нь шаардлагатай өрөө тасалгаа, цэвэр бохир ус, өрөөний халаалт, гэрэлтүүлгээр хангана. Шаардлагатай тохиолдолд автомашинаар хангана.

9.7 Ажилтны төлөөлөгчдийн гишүүдийн хурал хийх байрыг ажил олгогч гаргаж өгнө.

9.8 Ажил олгогч нь Ажилтны төлөөлөгчид хамтын гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээр хийх болон бусад үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

9.9 Ажилтны төлөөлөгч нь Байгууллагын болон хувь хүний нууцыг ханган ажиллана.

9.10 Хамтын гэрээнд тусгагдаагүй ажилтны эрх ашигтай холбогдсон асуудал гарвал Талууд хамтран хэлэлцэж, хуулийн дагуу шийдвэрлэнэ.

9.11 Байгууллагын төсвийн хуваарилалт, зарцуулалтын ил тод байдлыг хангахад Ажилтны төлөөлөгчийн оролцоог хангаж, мэдээлэл солилцож ажиллана.

9.12 Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, идэвхтэн, сонгуультан, Үйлдвэрчний эвлэлийн сургалтанд хамрагдах хурал, зөвлөгөөн, семинар, ярилцлагад оролцох үед цалинтай чөлөө олгон, албан тушаалыг хэвээр хадгална.

9.13 Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн зөвшөөрлөөр татварыг үндсэн цалингийн 1%-иар бодож бэлэн бус хэлбэрээр хурааж татварыг ҮЭХ-ны Голомт банкны 1205112569 тоот дансанд сар бүрийн 30-ны өдрийн дотор шилжүүлнэ.

9.14 Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй Үйлдвэрчний эвлэлийн сонгуультан болон Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийг Олон улсын, салбарын, орон нутгийн болон Үйлдвэрчний эвлэлийн хурал зөвлөгөөн, сургалт, семинар, дамжаа, туршлага солилцох хурал болон бусад үйл ажиллагаанд оролцох тохиолдолд цалинтай чөлөө олгож оролцуулах арга хэмжээг авна.

9.15 Төвийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон дотоод журам, ажилтнуудын эрх ашигтай холбогдох асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа Ажилтны төлөөлөгч болон салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд ажлын 15 хоногийн өмнө урьдчилан

мэдэгдэж санал авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хурал, зөвлөгөөнд Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оролцуулна.

АРАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

10.1 Ажилтны төлөөлөгч нь Ажил олгогчтой энэ гэрээ болон Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр харилцана.

10.2 Энэхүү хамтын гэрээ нь түүнийг бүртгүүлж баталгаажуулсан өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд мөрдөгдөнө. Хугацаа дуусах үед талууд гэрээг шинэчлэх санал гаргаагүй бол хугацаа дахин мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

10.3 Гэрээний хугацаа дуусахаас өмнө өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд талуудын зөвшилцсөний үндсэнд өөрчлөлтийг оруулна. Нэмэлт өөрчлөлт оруулахтохиолдолд энэхүү гэрээг байгуулсан журмыг баримтална.

10.4 Талууд хамтын гэрээг мөрдлөг болгон ажиллана. Хамтын гэрээг жил бүрийн 4 дүгээр улиралд 1 удаа дүгнэж, харилцан мэдээлж, ажлын тайланг Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, нийт ажилтнуудад тавина.

10.5 Талууд гэрээний хэрэгжилттэй холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг солилцох үүрэг хүлээнэ.

10.6 Хамтын гэрээний харилцан тохиролцсон асуудлыг зохих хугацаанд нь биелүүлэх үүргийг талууд харилцан хүлээх ба тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан биелэлтийг хангахад хяналт тавин ажиллана.

10.7 Ажилтны төлөөлөгч нь нийт ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалагчийн хувьд хамтын гэрээнд орсон асуудал бүрийг хугацаанд нь биелүүлэхийг шаардах, биелэлтийн явцыг байгууллагын удирдлагад болон хамт олонд мэдээлнэ.

10.8 Үйлдвэрчний эвлэлийн гишүүд болон тэргүүлэгчид нь асуудал дэвшүүлж үзэл бодлоо илэрхийлэхдээ хувь хүн болон байгууллагын нэр хүндэд халдахгүйгээр эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээ, холбогдох хууль дүрэм, журмыг чанд баримтална.

10.9 Ажилтны төлөөлөгч нь гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.

10.10 Хамтын гэрээг биелүүлэх явцад үүссэн санал зөрүүтэй асуудлыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.11 Хамтын гэрээнд тусгагдаагүй ажилтны эрх ашигтай холбогдсон асуудал гарвал Талууд хамтран хэлэлцэж, хуулийн дагуу шийдвэрлэнэ.

10.12 Дэлхий нийтийн болон улс орныг хамарсан асуудал тулгарвал тухайн цагт нь хамтран хэлэлцэж асуудлыг шийдвэрлэнэ.

10.13 Хамтын гэрээний заалт зөрчсөн буруутай тал, хувь хүн, хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу сахилгын ба захиргааны хариуцлага хүлээнэ.

10.14 Ажил олгогчийн зүгээс зохион байгуулж байгаа хамт олны нийтийн үйл ажиллагаанд хамт олныг идэвхтэй хамруулах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар Ажилтны төлөөлөгч идэвх зүтгэлтэй ажиллана.

10.15 Хамтын гэрээ байгуулах, биелүүлэх, хэрэгжүүлэх, тайлбарлах, нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэх үед талуудын хооронд маргаан үүсвэл зөвшилцлийн журмаар урьдчилан шийдвэрлэх, харилцан тохиролцох арга хэмжээг авна. Хэрэв талууд харилцан тохиролцож чадахгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

10.16 Захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн хороо нь өөрийн дүрэм, журамд заасан үйл ажиллагаа явуулахдаа бусдын болон гэрээлэгч талуудын нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдахгүй, гутаан доромжлохгүй байх үүргийг харилцан хүлээнэ.

10.17 Энэхүү хамтын гэрээг дараагийн хамтын гэрээ байгуулагдтал хүчин төгөлдөр мөрдөнө.

ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ:

Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа
эрхэлсэн дэд захирал

Д.Баярсайхан

Хүний нөөцийн албаны дарга

Ж.Баярсайхан

Санхүү бүртгэлийн албаны дарга

Г.Хунзаяа

АЖИЛЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:

ҮЭХ-ны дарга

С.Оюунгэрэл

ҮЭХ-ны тэргүүлэгч гишүүн

Д.Энхбаяр

ҮЭХ-ны тэргүүлэгч гишүүн

Б.Бат-Эрдэнэ

БҮРТГЭСЭН:

БЗД-ийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
Хөдөлмөрийн бүтээмж, харилцаа,
хөдөлмөрийн аюулгүй байдал
хариуцсан мэргэжилтэн

Э.Сайхантуяа

БҮРТГЭВ
№ 18
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
2025 он 06 сар 26 өдөр
Э.Сайхантуяа